

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ДАЯАРШИЛ

Ц.Баатар*

Оршлын оронд

Өнөөдөр Хятадын эдийн засгийн өсөлт хөгжил бүс нутгийн төдийгүй дэлхий нийтийн анхаарлын төвд орж ирлээ. Зарим төлөгчид энэ зууныг Хятадын зуун ч гэх болов. Юутай ч Хятадын эдийн засаггүйгээр дэлхийн эдийн засгийг төсөөлөх аргагүй болсныг шинжээчид хүлээн зөвшөөрч байгаа билээ. 2005 оны эхний хагаст Монголд ирж лекц уншсан Нобелийн шагналт, АНУ-ын Колумбын их сургуулийн профессор Роберт Манделл дэлхийн эдийн засгийн асуудлыг хөндөж ярихдаа байнга Хятадаас жишээ татаж байсан нь жирийн нэг тохиолдлын хэрэг биш. Тэр их хүн Хятадын хөгжлийг хүлээн зөвшөөрч, түүний дэлхийн эдийн засагт үзүүлж буй нөлөө тусгалыг анхааралтай судалсны илрэл биз ээ.

Ийнхүү Хятадын болон дэлхийн эдийн засаг улам бүр харилцан хамааралтай болж даяаршсаар байна. Нэг талаар бид хөрш их гүрний эдийн засгийн өсөлт хөгжлийг бусад орон гүрнээс хамгийн илүү их мэддэг мэдэрдэг. Хятад орноор явж, хөгжлийг нь нүдээр үзээгүй монгол хүн бараг байхгүй гэхэд ч болно. Нөгөө талаас бид энэ орны эдийн засгийн өсөлт хөгжлийн нарийн ширийн учир начирын талаар юу ч мэддэггүй гэхэд хилсдүүлэг болохгүй биз ээ. Чухамхүү ийм санаа сэдлийн үүднээс Хятадын шинэтгэл, Хятадын онцлогтой социализм, хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тулгамдсан асуудлууд, эдийн засгийн даяаршил, регионализмын талаар Хятадын баримталж буй байр суурь гэх мэт асуудлыг цухас хөндөж энэхүү бэсрэг өгүүллийг чадан ядан тэрлэв

Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн загварын хувьсал

Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн загварын хувьсал сүүлийн 20 жилийн хугацаанд бүрэлдэн тогтсон гэж хэлж болох бизээ. Шинэтгэлийн явцад өмнөх эдийн засгийн хөгжлийн үндсэн үзэл баримтлал болж байсан аж ахуйг эрхлэн хөтлөх захиргаадан удирдах, төвлөрсөн төлөвлөгөөт хуваарилалтын зарчмаас аажмаар татгалзаж, зах зээлийг баримжаалсан Хятадын онцлогтой уялдуулсан бодлого явуулж ирэв. Үүний үр дүнд тус улсын эдийн засгийн амьдралд зах зээлийн механизм, түүний зүй тогтол нутаг дэвсгэр болон аж ахуйн салбаруудад үе шаттайгаар түгэн дэлгэрсэн аж.

Дээр өгүүлэн буй “нутаг дэвсгэр” гэдэг нь эхлээд Хятадын эдийн засгийн тусгай бүсүүд болон эрэг орчмын районуудад зах зээлийн механизмыг туршиж, дараа нь тус орны нутгийн гүнд түгээн дэлгэрүүлж буйг хэлж байгаа хэрэг. “Салбаруудад” гэдэг нь зах зээлийн механизмыг

* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Хятадын эдийн засгийн бүхий л салбаруудад нэгэн зэрэг “туршиж үзээгүй” харин эхлээд хөдөө аж ахуйн салбар, жижиг дунд бизнес, үйлчилгээний хүрээ, экспортын үйлдвэрлэлд нэвтрүүлж, үр ашигтай болох нь батлагдсаны дараа сая л эдийн засгийн бусад салбарт түгээн дэлгэрүүлснийг хэлж байгаа хэрэг.

Хятадын эдийн засгийн хөгжлийн загварын мөн чанарыг ойлгоё гэвэл “зах зээлийн эдийн засгийн” ойлголт, түүний төрийн зохицуулалтын тухай эсрэгээр тайлбарлах бус харин социализмын аж ахуйн субъектуудын хоорондын харилцаанд үйлчилж байсан захиргаадан хуваарилах механизмыг эсрэгээр авч үзэх нь чухал. Энэ үүднээс авч үзвэл Хятадын эдийн засгийн хөгжлийн загварын гол үр дүн нь өнгөрсөн зууны 1990-ээд оны сүүлчээр үндсэндээ зах зээлийн эдийн засгийн харилцааны хэв маягт шилжсэн явдал юм.

Хятадын онцлогтой хөгжлийн загварын гол үзэл баримтлал нь зөвхөн үйлдвэрлэлийн материаллаг бодит хүчин зүйлүүдийг төдийгүй санхүүгийн нөөц баялагийг хуваарилах замаар эдийн засагт оролцдог төрийн үүрэг роль хийгээд хувийн секторын өсөн нэмэгдэж байгаа үүрэг ролийг хүлээн зөвшөөрч үнэлж цэгнэх болсон явдал юм.

Энэ шатанд Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн загварын хувьслын мөн чанар нь зөвхөн эдийн засгийг зах зээлийн захиргаадан-хуваарилахын эсрэг механизмууд аль хир өргөн цартай, гүн гүнзгий нэвтэрч байгаад төдийгүй захиргаадан-хуваарилахаас ялгаатай зах зээлийн зарчмуудад тулгуурлан хэрэгжиж байгаа Хятадын эдийн засгийн стратегийн зорилго, арга хэрэгслийн агуулгыг өөрчлөхөд үндсэндээ чиглэсэн юм.

Шинэтгэлийн явцдаа Хятад улс гагцхүү зах зээлийн эдийн засагтай орнуудтай хамтран ажилладаг байгууллага болох Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-д элсэхийн тулд бүтэн 15 жил зарцуулж байж, тэдний зүгээс тавьсан бүх нөхцөл, болзлыг хүлээн авч 2001 онд сая л уг байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон нь тохиолдлын хэрэг бишээ. Энэ үйл явц Хятадын эдийн засгийн хувьд эерэгээр ч, сөргөөр ч нөлөөлсөн гэж судлаачид үздэг.

ДХБ-д элссэн явдал нь Хятадын хувьд АНУ, Өрнөд Европын нэн баялаг зах зээлийг нээж өгөхийн сацуу Хятад улс эдийн засгийнхаа хамгийн эмзэг сектор болох санхүүгийн хийгээд хөдөө аж ахуйн секторыг дэлхийн зах зээлд нээж өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэсэн юм. Тус улсын удирдлага энэ бүхнийг авч үзэхдээ “Хятадын хувьд ДХБ-д элсээгүй байх үеийн худалдааны ашиг нь ДХБ-д элссэнээс хойш зайлшгүй гарах зардлаас хол давна” гэсэн тооцоог иш үндэс болгосон байна.

Нөгөө талаар даяаршлын үйл явцад оролцохгүй бол шинэтгэлд илүү их аюул занал учирна гэж Хятадын удирдлага үзсэн учир Бээжин Өрнөдийнхний аль эртнээс шаардсаар ирсэний дагуу санхүү, хөдөө

аж ахуйн салбараа шинэ зууны босгон дээр АНУ болон Европын Холбоо /ЕХ/-нд нээж өгсөн юм.

Хятад улс ДХБ-д элссэний дараахи эхний жилүүдэд ажил эрхлэлт 2%-иар буурна гэж тооцоолж байсан. Гэтэл энэ асуудал хөдөө аж ахуйн салбарт төлөвлөж байснаас илүү хүндээр туслаа. Одоо ч Хятадын хөдөө тосгонд ажилгүйдэл нүүрлэж хот руу чиглэсэн их нүүдэл үргэлжилсээр байна. Гэвч ДХБ-д элссэнээс хойшхи эхний таван жилд БНХАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ өсөлт 1.5 хувийн үзүүлэлтээр, экспортын өсөлт 27 хувийн үзүүлэлтээр, импортын өсөлт 26 хувийн үзүүлэлтээр, хөрөнгө оруулалтын өсөлт 2 хувийн үзүүлэлтээр тус тус нэмэгдэнэ гэж тооцож байсан бол дээрхи үзүүлэлтүүд өнөөгийн байдлаар хэд дахин даваад байгаа билээ. Түүнчлэн ДХБ-д элссэнээр Хятадын электроникийн болон мэдээллийн технологийн дотоодын зах зээлийг 35-40 хувиар өргөтгөж, ДНБ-ийг 10-12 хувь хүртэл нэмэгдүүлэх боломж бүрджээ.

Хятад улс ДХБ-д элссэнээр хөгжил дэвшилээ хурдасгаж даяаршлын үр шимийг хамгийн их хүртэж байгаа орны нэг болоод байна.

Хятадын шинэчлэлтийн гол үр дүн

Хятадын нийгэм-эдийн засгийн загварын нэг ёсны үзэл баримтлалын гол ноён нуруу нь гадаад орнуудын, юуны өмнө БНСУ, Тайвань, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй Азийн улсуудаас Хятадын өвөрмөц онцлогт тохирох арга туршлагыг шууд хуулбарлан ашиглах явдал юм. Хятадын шинэтгэлийн гараа 1978 оны 12-р сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 11 дэх удаагийн III бүгд хурлаас эхэлсэн гэж үздэг. Хятад улсад “соёлын хувьсгалын болон захиран тушаах аж ахуйн системийн ноёрхлын жилүүдэд учирсан хохирол тэр үед тус улсын удирдлагын хувьд тов тодорхой болжээ”. Хятадад хүнс, хувцас, түлш, орон сууц илт дутагдаж, хэрэглээний бараг бүх зүйл картаар хуваарилаж байв. Тус орон өлсгөлөн, нийгэм-улс төрийн тогтворгүй байдлын даваанд тулж ирээд байв.

“Ревизионист” гэгддэг байсан ЗСБНХУ, “империалист” гэгддэг байсан АНУ зэрэг Хятадын гадаад хүрээллийг Бээжин улс орныхоо тусгаар тогтнолд шууд цэргийн аюул занал учруулж буй эх үндэс хэмээн үздэг байв. Ийм нөхцөлд Хятадын удирдлага амьдралын шаардлагаар наанадаж Хятадын тэрбум хүн амыг харьцангуй тайван байдалтай байлгаж, засгийн эрх мэдлийг ХКН-ын гарт хадгалж, гаднын дайснагасан /Бээжингийн үздэгээр/ шахалтыг сөрөн зогсож, хөгжлийн захиргаадан-хуваарилах эдийн засгийн загвараа өөрчлөхөөс өөр аргагүй болжээ.

Хятадын загварын мөн чанар нь Хятадын тэрбум гаруй хүн амын нийгэм-улс төрийн тогтвортой байдлыг хангаж, “дотоод зорилго” дэлхийн хөгжингүй орнуудаас хоцорч буй тус улсын нийгэм-эдийн засгийн хийгээд технологийн хоцрогдлыг эдийн засгийн өсөлтийн хурдацыг нэмэгдүүлэх

замаар арилгахад “гадаад зорилго” оршиж байв. Энэхүү “гадаад зорилго” хэрэгжүүлэхийн тулд аж ахуйн санаачилгыг төрийн бус эх үүсвэрүүдэд олгох, дэмжих замаар эдийн засгийн эрх чөлөөг нь аажим аажмаар улам бүр нэмэгдүүлэх замаар, нөгөөтэйгүүр “командын өндөрлөгүүд” гэгчийгээ төрийн мэдэлд хэвээр хадгалах замаар хангаж ирлээ.

Эдийн засгийн өндөр өсөлтийн стратегийн үндсэн бүрдэл нь:

Тариацдад нэмэлт эрх, тухайлбал, аж ахуйг эрхлэн хөтлөх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах, газар ашиглах эрхээ хадгалах зэрэг нэмэлт эрх олгосон хөдөө аж ахуйн шинэтгэл хийх; (Тэгэхдээ газар нь өөрөө одоохондоо төрийн өмч хэвээр байгаа ба түүнийг худалдаж болдоггүй. Хятад улс ДХБ-д элссэн нь газрыг худалдах, худалдаж авах тухай маргааныг идэвхжүүлжээ. Ц.Б)

Ялангуяа худалдаа, үйлчилгээний хүрээнд жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэх явдлыг бүх талаар хөхүүлэн дэмжих;

Гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татаж, дэлхийн тэргүүний туршлагыг, ялангуяа үйлдвэрлэлийн сайн дэд бүтэцтэй, татварын хөнгөлөлт бүхий экспортын тусгай бүс байгуулдаг Азийн туршлагыг ашиглах замаар экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

Санхүү аж үйлдвэрийн томоохон газар, тээвэр холбоо нийгэм хангамжийн системд төрийн хяналт тогтоох зэрэг болно.

1970-1990-ээд оны Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар нь экстенсив шинжтэй байв. Аж үйлдвэрийн хийгээд ахуйн хэрэглээний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх чанарыг сайжруулах асуудлыг одоо болтол эн тэргүүнд тавиагүй байна. Энэ загварыг авч үзвэл төр нь алдагдалтай томоохон үйлдвэрийн газар, уян хатан биш санхүүгийн байгууллага, хөрөнгө хүч их шаарддаг түлш эрчим хүчний цогцолбор, тээвэр үйлдвэрлэлийн дэд бүтцийг дэмжих замаар өөртөө санхүүгийн дарамт учруулж байв.

Шинэтгэлийн явцад Хятадын удирдлага нь “очир эмчилгээний” болон шавдуу хувьчлалын аргуудыг хэрэглэсэнгүй. Хятадын эдийн засгийн стратегийн ийм шинж байдал нь заримдаа тус улсын хөгжлийн эдийн засгийн улс төржсөн, үзэл сурталжсан загвартай холбоотой. Хятадын коммунист нам нь улс төрийн эрх мэдлийн монопол байдалд аюул занал учруулж болзошгүй эдийн засгийн хөгжлийн тэдгээр чиглэлд туйлын болгоомжтой хандаж ирсэн, хандсаар ч байгаа билээ. Хувийн өмчид сөргөөр тэр байтугай дайсагнан ханддаг ягшмал /ортопоксаль/ марксист үзэл баримталж ирсэн нь Хятадын удирдлагыг, наанадаж түүний хамгийн хуучинсаг үзэлтэй хэсгийг хувийн өмчид /төрийн өмчтэй харьцуулвал/ нийгмийн хувьд өмчийн хамгийн үр ашиггүй хэлбэр мэтээр үзэж, түүнд удаан хугацааны туршид тааламжгүй хандахад хүргэжээ. Гэхдээ Хятадын удирдлага зөвхөн үзэл суртал, улс төрийн болгоомжлолоосоо болоод “очир эмчилгээ”, хувьчлалаас татгалзсан гэж шууд хэлбэл зүйд нийцэхгүй байх аа.

Учир нь онолын үүднээс авч үзвэл эдийн засаг дахь зах зээлийн тэнцвэрт байдал /зөвхөн үнийг чөлөөлж, эдийн засгийн санаачилгыг төрийн эх үүсвэрүүдийг хувьчилсны үр дагавараар бий болдог/ нь хараахан нийгмийн хэрэгцээ шаардлагаар бий болдоггүй. Үүнийг эрэлт, нийлүүлэлтийн харьцааны жишээн дээр харуулъя.

Онолын хувьд “цэвэр” зах зээлийн хангалттай хөгжингүй эдийн засагт барааны үнэ түүний шаардлагатай тоо хэмжээ нь нэг талаас үйлдвэрлэлийн зардлаар, нөгөө талаас эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдлаар тодорхойлогддог нь мэдээж билээ. Үйлдвэрлэгчийн зорилт нь барааны эрэлт хэрэгцээний хэмжээг боломжийнхоо хирээр нарийвчлан тодорхойлоход үнийг бууруулж эрэлтийг нэмэгдүүлэх замаар тэгэхдээ бараагаа аль болох их борлуулан, их ашиг олох замаар үйлдвэрлэлийн зардлаа багасгахад оршино.

Хятадын хандаж байгаа шилжилтийн эдийн засагт нөхцөл байдал арай өөр юм. Гагцхүү хожим хойно хөрөнгө хуримтлуулж, технологийн улам буурч буй зардлыг нөхөн, хэрэглэгч баяжихын хирээр энэ нь “хэвийн” байдалд орно гэсэн зарчим баримталж ирлээ.

Хөгжингүй бус зах зээлд, өөрөөр хэлбэл ядуу хэрэглэгчтэй, хөрөнгө хүрэлцээгүй, тэргүүний технологи байхгүй зах зээлд худалдан авагчийн хувьд хамгийн боломжтой барааны үнэ нь үйлдвэрлэлийн зардлаасаа доогуур байх тохиолдол бий. Учир нь худалдан авагч үйлдвэрлэгчийн зардлыг нөхөхүйц үнийг төлж чаддаггүй. Үүнээс болоод бараа нь нийгэмд хэрэгтэй байлаа ч ашиг олох үүднээс барааг үйлдвэрлэх боломж байдаггүй. Хэрэв бид үүнийг графикаар дүрслэн үзүүлбэл эрэлт нийлүүлэлтийн муруйнууд нь ерөөсөө огтлолцохгүй. Бидний авч үзэж буй энэ нөхцөлд үйлдвэрийн газар нь ашиг олохын үүднээс барааг үйлдвэрлэж чадахгүй. Яагаад гэвэл хэрэглэгчдэд тохирох үнэ, үйлдвэрлэлийн зардал хоёрын ялгаа нь сөрөг байна. Энэ нь үйлдвэрлэлийн зардал, үнэ хоёрын ялгааг хэн нэг нь нөхөх ёстой гэсэн хэрэг юм. Тухайлбал, хэрвээ энэ хэрэгцээг нийгмийн хувьд амин чухал шаардлагатай гэж үзвэл түүнийг төрөөс нөхөн төлдөг. Төрийн оновчтой үйл ажиллагаа нь зах зээлийн учир зүйн үүднээс авч үзвэл үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, үйлдвэрлэгчид ашиг олох, ашигтай ажиллах тийм нөхцөл байдлыг бий болгоход чиглэх ёстой.

Мэдээж, зардлын бууралт нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй холбоотой бөгөөд үүнийг үйлдвэрлэлээ томсгох юмуу эсвэл илүү үр бүтээмжтэй технологийг нэвтрүүлэх замаар бий болгоно.

Тухайн технологийн үед цаашдаа үйлдвэрлэлийн зардал буурахад хүргэхгүйгээр үйлдвэрлэлээ дээд зэргээр томсговол шинэ технологийн болон хөдөлмөрийн шинэ “үзэл санааны” эрэлт бий болно. Тэгэхдээ үйлдвэрлэгчийн хувьд хуучин хэрэгцээгээр ажиллах хүсэл сонирхолгүй

болж, ажлаа орхих сонирхол бий болж магадгүй. Учир нь энэ хэрэгцээг цаашид хангах явдал нь ашгаа өсгөх боломж олгохгүй бөгөөд хуучин зарцуулж байсан зардлаараа илүү их ашиг олох найдлага бүхий өөр ажилд шилжих аргагүй байдаг. Энэ тохиолдолд “орхигдсон” хэрэгцээ нь дахин дээрээс, өөрөөр хэлбэл эдийн засгийн санаачилгын төрийн эх үүсвэрүүдийн зүгээс оролцох шинэ хувилбар хэрэглэхийг шаарддаг.

Үнийг үйлдвэрлэлийн зардлын хэмжээнээс илүүгээр нэмэгдүүлэх замаар ч ашгийг өсгөж болдог. Гэвч практик дээр энэ замыг гагцхүү хэрэгцээний хязгаарлагдмал хүрээгээр, хүн амыг нийтэд нь чинээлэг болгох зайлшгүй нөхцөлд сонгон хэрэглэж болно. Иймэрхүү үйл ажиллагаа явуулах нь хэрэглэгч хүмүүс буюу хувийн үйлдвэрлэгчид амин чухал бүтээгдэхүүнийг /хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай/ шаардлагатай хамгийн бага хэмжээгээр ч худалдан авч үл чадах гийм нөхцөл байдлыг бий болгож мэднэ.

Тухайн онолын үзэл бодол нь Хятадын удирдлага чухамдаа ийм тайлбарыг хүлээж авах эсэхээс үл хамааран, эсвэл Хятадын ертөнцийг үзэх үзлийн уламжлал, эрс огцом өөрчлөлтийн /”их үсрэлт”, “соёлын хувьсгал”/ түүхэн сөрөг туршлагаас үндэс язгууртай бусад хүчин зүйлтэй хамтад нь авч үзэх өөр үзэл бодлоос үл шалтгаалан “градуализмын”(өөрчлөлтүүдийг урт удаан хугацаанд шат шатаар хийх Хятадын үзэл баримтлал) зарчим Хятадын шинэчлэлтийн гол зарчмын хувиар гарч ирэх нөхцлийг бүрдүүлж өгчээ. Градуализм нь Хятадад XIX зуунд эхлэл нь тавигдаж, XX, XXI зуунд үргэлжилж буй түүхэн үйл явцыг өргөн утгаар нь авч үздэг ойлголт. Хятадын судлаач, шинжээчид энэ үзэл баримтлалд хамгийн нийтлэг байдлаар хандаж хүлээн зөвшөөрдөг. Градуализм Хятадын шинэчлэлтийн үзэл баримтлалын хувьсалд, түүнийг практикт хэрэгжүүлэх хурдацын өөрчлөлтөд тод илэрч харагддаг. Үүний дотор төлөвлөгөөт зах зээл гэх мэт Хятадын эдийн засгийн загварын бааз бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан уялдаа холбооны асуудалд хэрхэн хандаж буй хандлага ч харагддаг. Градуализм ДХБ-тай хэлэлцээ хийх явцад Хятадын тактикийн арга хандлагад ч нөлөөлсөн тухайлбал, Хятад улс санхүүгийн системээ либералчлахад зориулан өөртөө 5 жилийн хугацаа олгуулж чадсан. Хятадын эдийн засгийг өөрчлөн байгуулахаар сонгосон стратегийг амжилттай гэж үнэлж цэгнэхгүй байх аргагүй. Шинэтгэлийн 20 жилийн хугацаанд Хятадын ДНБ 1978 онд 360 тэрбум юань байсан бол /мэдээж, үндсэн болон хэрэглээний барааны төвлөрсөн хуваарилалтын зарчмаар амьдарч байсан тус орны ДНБ-ний өртгийн үзүүлэлтийг тодорхой хэмжээгээр харьцангуйгаар тооцоолж байсан гэхэд шүү дээ/ 2002 онд 10.6 триллион юань болтлоо бараг 30 дахин өсчээ. Эдгээр жилүүдэд хүн амын дундаж орлого 30 дахин, мөнгөн хадгаламж 400 дахин өсч, 1980-1990-ээд онд Хятадын ДНБ-ийн өсөлтийн жилийн дундаж хурдац 10%

орчим, аж үйлдвэрийнх 16%, хөдөө аж ахуйнх 7% тус тус болжээ. Хятад улс 1997-1998 оны Азийн санхүүгийн хямралын цохилтоос өөрийгөө хамгаалж, 1998-2002 онд эдийн засгийн өсөлтийн жилийн дундаж хурдныг 7.5 гаруй хувийн хэмжээнд барьж чаджээ. Түүнээс хойшхи хугацаанд SARS болон зарим таагүй зүйл нөлөөлсөн хэдий ч өндөр өсөлтөө хадгалж ирэв. Хятадын эдийн засаг барагцаагаар дөрөвний гурван хувиар зах зээлийн удирдамжийн төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрлэгддэг аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ 5%-иас хэтрээгүй. Хятад нь ДНБ-д улсын секторын эзлэх хувь 40 хувь орчим болж буй холимог эдийн засагтай орон юм. Гэхдээ Хятадын эдийн засгийн өсөлтийн чанар 1978 оноос хойшхи хугацаанд тийм ч сайн байсангүй. Тус орны хөгжил гол төлөв хуримтлалын өндөр хувь хэмжээнд /35-55%/, хөрөнгө оруулалтын хийгээд зээлийн байнгын шахуурганд тулгуурлаж ирсэн ба нөөц баялагийг ашиглах үр нөлөө багатай байдлаар тэнцвэрт байдал ноптой алдагдах явдлаар /эдгээрээс хамгийн аюултай нь тус орны тэнгисийн эргийн болон дотоодын районуудын хоорондын, хот, тосгоны хоорондын хөгжлийн түвшин дэх зааг ялгаа улам ихэсч буй явдал юм/ тодорхойлогдож байв. Хятад улс эдийн засгийн өндөр эрч хүчээс дэндүү хараат байдалтай бөгөөд ийм эрч хүчийг хэвээр хадгалах шаардлага нь тус орны өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийн нөөц баялагийг үрэн таран хийх хувилбар руу байнга чангаан оруулж, бүтцийн маневр хийх бололцоог ихээхэн хязгаарлаж иржээ. Хятад улс одоогоор эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийж чадаагүй байна. 1990-ээд оны дундуур үйлдвэрлэлийн болон хөдөлмөр их шаарддаг бүтээгдэхүүний /бөс бараа, гутал, удаан эдэлгээтэй ахуйн өргөн хэрэглээний техник/ экспортыг түргэн хурдацтай нэмэгдүүлэхэд ихээхэн хэмжээгээр тулгуурласан эдийн засгийн хөгжлийн стратегийн үр нөлөө буурч буй тодорхой шинж тэмдгүүд бий болжээ. Аж үйлдвэрийн хөгжлийн хүндийн төвийг машины үйлдвэрлэл, электроник, автомашины үйлдвэрлэл, нефть-химийн үйлдвэрлэл, барилга байгуулалт зэрэг тэргүүлэх шинэ бүлэг салбарт зугуухан шилжүүлэх ажил нь санаснаас хамаагүй их бэрхшээлтэйгээр хэрэгжиж байна.

Хятадын засгийн газраас хэт халсан эдийн засгаа амраах хүчин чармайлт тавьж, зээл ихээр олгох явдлыг тогтоон барьж, өсөлтийн тэнцвэртэй загварт түлхүү анхаарч байна.

АХБ-ны жил тутмын “Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал 2004” товхимолд дурдсанаар Хятадын эрчимтэй хотжилт, хүн амын орлогын өсөлттэй уялдан хэрэглээний өсөлт 2004, 2005 онд есөн хувь орчимд хүрч, хөрөнгө оруулалт бараг 50 хувиар буурч жилд 16 хувь орчим байх аж. 2004, 2005 онд өсөлт үргэлжлэх боловч хурдац арай буурч 15 орчим хувь байна. Экспортын татварыг бууруулж хөнгөлөлт үзүүлсэн явдал үүнд эерэгээр нөлөөлнө. Худалдааны талаархи зөрчил,

ялангуяа АНУ болон Европын Холбоотой хийх худалдаанд гарсан зөрчил 2004, 2005 онд улам нэмэгдэж экспортын өсөлтөд саад үүсгэж болно. Эерэг талаас нь харвал дэлхийн эдийн засгийн сэргэлт худалдаанд дэмжлэг үзүүлнэ гэсэн таамаглал дэвшүүлсэн.

2005 оны урьдчилсан гүйцэтгэлээс үзэхэд Хятадын ДНБ тогтвортой өсөлтөө хадгалж 9 хувийн өсөлттэй байгаа аж. АХБ-ны таамаглаж байсанчлан АНУ, Европын Холбоотой хийх худалдаанд нэлээд ширүүн зөрчил маргаан гарч БНХАУ-ын зүгээс АНУ болон Европын Холбооны орнуудтай бодлогоо эрс хурцатгах болсон нь энэ оны эхээр олон улсын худалдаанд бөс даавуу бэлэн бүтээгдэхүүний импортын квотыг цуцалснаас эхэлжээ. АНУ-ын статистикийн мэдээгээр БНХАУ-ын дээрхи төрлийн барааны экспорт зөвхөн 2005 оны 1-3-р сард 30 хувиар өсчээ. Мөн энэ хугацаанд богино ханцуйтай цамцны “T-Shirt” Европын Холбоо руу оруулах импорт 187 хувиар өссөн гэж Европын Комиссоос мэдэгдсэн байна. Түүнчлэн хөвөн материалаар хийсэн бүтээгдэхүүний экспорт 56 хувиар нэмэгджээ. Дэлхийн Худалдааны байгууллагын дүрэм ёсоор, хэрэв бөс даавуу импортлодог орны импортын хэмжээ нь 7.5 хувиас дээш өсвөл тухайн улс орон өөрийн дотоодын тогтвортой байдлыг хамгаалах үүднээс зохих хориг арга хэмжээ авахыг зөвшөөрдөг аж. Үүнийг үндэслэн Европын Комисс БНХАУ Европын Холбооны гишүүн орнуудын зах зээл рүү гаргадаг дээрх хоёр төрлийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг бууруулах шаардлага тавьсан. Энэхүү маргаан нэлээд удаан үргэлжилсэн боловч талууд буулт хийж маргааныг зохицуулж чадлаа.

Өнөөгийн Хятадын нийгмийн амьдралд банкны системийн сул байдал, улсын үйлдвэрийн газрын өөрчлөлт шинэчлэлт, ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллын системд өөрчлөлт шинэчлэлт хий зэрэг бэрхшээлтэй асуудлууд тулгарч байна. Түүнчлэн хөдөө нутгийн нэн ядуу 28 сая хүн амын ихэнхи нь экологийн тэнцвэр ноцтой алдагдсан цаашид ч хүн амьдрахын аргагүй газар нутагт амьдарч, зах зээлийн эдийн засгийн гадна орхигдож байна.

Хятадын онцлогтой социализм

Хятадын онцлогтой социализм гэж юу болох тухай мэтгэлцээн Хятадын шинэтгэл явагдаж эхэлсэн тэр цагаас өнөө хүртэл үргэлжилсээр байна. Энэ асуултын хариулт нь социализмын тухай ухагдахуунд багтааж буй тэр зүйлсээс шалтгаална. Хэрэв социализмыг орчин үеийн капиталист эдийн засгийн халааг авч буй бүх нийтийн түвшин жаргалтай нийгэм гэх юмуу аж үйлдвэржсэний дараах маягийн нийгэм хэмээн тайлбарлах явдлыг иш үндэс болговол Хятад улс тийм маягийн социализмаас Өрнөд Европ, АНУ-ыг бодоход хамаагүй хол байгааг хэлж байгаа юм. Тэгэхлээр

Хятадын онцлогтой социализм нь дэлхийн тэргүүлэх орнуудын мөрөөр Хятад гэдэг нэрийн дор яваа тодорхой орны хөгжлийн нөхөн гүйцэх хувилбар гэж үзэж болох биз ээ.

Хэрэв социализм гэдгийг, социализмын сонгодог улс төр-эдийн засгийн онолд зааснаар, хувийн өмчгүй нийгэм хэмээн ойлгох юмуу эсвэл хуучин зөвлөлт маягийн нийгэм хэмээн ойлговол “Хятадын онцлог” гэдэг нь юун түрүүнд Хятад улс хувийн өмч тус орны үйлдвэрлэх хүчний хөгжилд эерэг үүрэг гүйцэтгэх тийм маягийн “сонгодог”, “төрийн” социализмыг бүтээн байгуулах анхны боловсроогүй шатандаа байгаа хувилбар ч гэж хэлж болох. Хэрэв социализм гэдгийг эдийн засгийн ороо бусгаа хувь заяанаас хувь хүнийг хамгаалах асуудалд ихээхэн анхаардаг Өрнөд Европын одоо бодитой оршин байгаа зах зээлийн ардчилал хэмээн ойлговол Хятадын онцлог нь ахиад л түүний хоцрогдолтой өргөн цартай нийгмийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөц баялаг байхгүйтэй холбоотой. Түүнчлэн хэрэв “зах зээл ардчилал” гэдэг холбоо үгийн “ардчилал” гэсэн нэр томъёог онцлон авч үзвэл коммунист нам улс төрийн эрх мэдлийг монополичилдог нь Хятадын онцлог юм.

Хэрэв “хулгана л барьдаг бол ямар муур байх нь хамаагүй” гэх юмуу “эхлээд цэцэглэн хөгжиж буй нийгэм байгуулаад дараа нь түүндээ нэр өгнө” гэсэн Хятадын шинэчлэгчдийн дунд нэн түгээмэл дэлгэрсэн сэдвийг баримжаалах аваас “Хятадын онцлогтой социализм” нь социализмыг хүндэтгэн үздэг үзэл баримтлал ч гэж хэлж болно.

“Хятадын онцлогтой социализм”-ын үндсэн агуулга нь Хятадын коммунист намын гарт улс төрийн эрх мэдлийг хадгалах замаар дэлхийн аж ахуйн хэлхээ холбоо, дэлхийн шинжлэх ухаан-техникийн дэвшилд интеграцчилагдсан зах зээлийн эдийн засгийг бий болгоход оршино. “Зах зээлийн дангаар ноёрхох ёс” аль хир удаан хадгалагдах нь ирээдүйн асуудал. БНСУ, Тайвань, Сингапур зэрэг Азийн өндөр хөгжилтэй улсуудын туршлага нь нийгмийн сайн сайхан байдлын тодорхой түвшингээс эхлэн нийгмийн шилмэл хэсгийн хэрэгцээ, ардчилалд төлөвшсэний үр дүнд ангийн хэрэгцээ нь ямар ч хамаагүй үнэ цэнээр ноёрхогч байдлаа хадгалах гэсэн эрх баригчдын хэрэгцээг нийгмийн амьдралаас шахан түрж эхэлж байгааг харуулж байна. Хятад улс өөрийнхөө онцлог гэх эдийн засаг, улс төрийн загваруудыг хослуулах /коммунист нам улс төрийн эрх мэдлийг монополчлох замаар зах зээлийн эдийн засгийг бий болгох/ хувилбарыг зөвтгөхийн тулд аанай л Сингапур, Тайвань, БНСУ-ын туршлагыг шүүрч авах дуртай. дээрх орнуудад үнэхээр ч дангаар ноёрхох ёс саад болоогүй. Харин ч эхний шатуудад шинэчлэлт, эдийн засгийн цэцэглэн хөгжилд тус дөхөм болсон. Гэвч асуудлын гол нь Ази дахь коммунист, цэргийн хүнд-сурталт дэглэмүүд дор хаяад өөр хоорондоо нэг чухал ялгаатай байдагт оршино.

Энэ ялгаа нь хувийн өмчтэй харилцах харилцаатай холбоотой. Коммунист дэглэмүүд хувийн өмчийг дайсагнасан байдлаар болгоомжтойгоор дараа нь арга буюу эвлэрэнгүйгээр хүлээж авдаг ба энэ үндсэн дээр дэглэмийн прагматизмын хэр зэрэг бөх бат нь туршигдан шалгагддаг. Азийн цэргийн хүнд сурталт дэглэмүүд хувийн өмчийг гарцаагүй дэмждэг. Хувийн өмчтэй харилцах талаархи ялгаа нь: зах зээл+коммунист намын эрх мэдэл /"Хятадын онцлогтой социализм"/, зах зээл+цэргийн хүнд сурталт дэглэмүүд /1990-ээд оны эхэн үе хүртэлх БНСУ, Тайвань/ гэсэн хоёр загварын эдийн засгийн үр нөлөөний ялгааг тодорхойлдог. Хоёр дахь хувилбар нь практик дээр илүү үр нөлөөтэй, тухайлбал хувийн өмчид эерэг байдлаар хандах шалтгаанаар илүү үр нөлөөтэй болж байна. Хятад улс хөгжлийнхөө загварт хувийн өмчийн эзлэх байр суурь, үүрэг ролийг тодорхойлох талаар арга буюу засвар оруулах болсон нь тохиолдлын хэрэг биш. Эхлээд хувийн өмчийг гагцхүү жижиг дунд үйлдвэрийн газруудын хэлбэртэй юмуу гадаадын иргэдийн мэдэлд байвал л системийн үр ашигтай бүрдэл хэсэг мөн гэж хүлээн зөвшөөрдөг байв. 1999 оны сүүлчээр тус орны үндсэн хуульд өөрчлөлт оруулж, хувийн өмчид төрийн өмчийнхтэй адил эрх эдлүүлэхийг зөвшөөрсөн. Улмаар 2005 онд дахин өөрчлөлт оруулж хувийн өмчийг хуулиар хүлээн зөвшөөрлөө. Энэ бүхэн нь Хятадын олон хэвшлийн эрх зүйн бааз суурийг тавьж өглөө. Хятад улс Азийн өндөр хөгжилтэй орнуудын замаар замнаж, хийх ёстой дараагийн алхам нь газар өмчлөх эрхийг хүлээн зөвшөөрч төрийн томоохон үйлдвэрийн газрууд, санхүүгийн байгууллагуудыг хувьчлах явдал гэж үзэж болох юм. Хятадын хувьд энэ алхмын нийгэм, улстөрийн үр дагавар нь янз бүр байж болох хүнд хэцүү алхам учраас үүнийгээ хэрэгжүүлэх цаг хугацааг нарийн тооцож буй нь мэдээж. Хувийн өмчид хандах хандлагын хувьсал нь зөвхөн Хятадын нийгмийн нийгэм-эдийн засгийн төдийгүй улстөрийн загварын хувьслын үндсэн онцлог, гол цөм нь гэж үзэж ч болох биз ээ.

Хятадын онцлогтой социализмыг коммунист намын засаг төрийн монополь эрхийг хадгалах замаар дэлхийн эдийн засгийн зах зээлд интеграцчилагдаж буй зах зээлийн социализм хэмээн тайлбарлах явдал нь дэлхийн орчин үеийн улс төр-эдийн засгийн газрын зураг дээр Хятадын эзлэх байр суурийг илүү тодорхой мэдэж, Хятадын нийгмийн цаашдын хувьслын замыг ойлгох боломж олгож байна.

Үргэлжлэл дараагийн дугаарт